



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/014/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Намчинсүрэн

Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг: Аудитын санал дүгнэлт	2
Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 4үзүүлэлтүүд.....	4
Гурав. Аудитын илрүүлэлт	5
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:	7

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.08.24 № 274
танай _____ ны № _____ т

Баян-Агт сумын Засаг
Даргын Тамгын Газрын Дарга
М.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитын тайлагналтай холбоотой нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 50.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 37.0 сая төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархаагүй тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө. Үүнд:

- Нийт 4 албан хаагчдад илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгохдоо холбогдох журмыг зөрчин 5.9 сая төгрөгийг олгосон;
- Сумын ЗДТГ-ын даргад гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан тушаалтны ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж үндсэн цалингийн 40 хувиар тооцож нийт 4.1 сая төгрөгийг олгосон;
- Төрийн албан хаагчийн эзгүй орон тоог түр орлон гүйцэтгэсэний цалинг 5.9 сая төгрөгийг илүү тооцон олгосон;
- Улиралын үр дүнгийн урамшууллыг олгохдоо холбогдох тушаал, шийдвэр

6326050394

гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлж дүгнээгүйгээр 1 албан хаагчид 0.7 сая төгрөгийг олгосон;

- Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг" журмыг зөрчин 5.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч зориулалт бус зарцуулсан, орлогод авч бүртгэлжүүлээгүй;
- Албан хаагчийн хувийн дансруу зохион байгуулах арга хэмжээний 13.5 сая төгрөгийн зардлыг шилжүүлэн зарцуулсан, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, тухайн албан хаагчаар нэхэмжлэл үүсгэн ХХОАТ-ыг суутган тооцсон;
- Нэмэлт дансны 4.5 сая төгрөгийн шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс аймаг, сумын аваргаар тодорсон малчдад гарын бэлэг, дурсгалын зүйлд зориулан нийт 6.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин тэмцээн зохион байгуулж "Жудо" бөхийн тэмцээнд 2.0, "Шагайн харваа" тэмцээнд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан зэрэг нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 23.6, 58.1.1, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хасвралт 2.4, 2.5, Сангийн сайдын Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолын 3.6.11, 3.6.8, 4.4.3.4-д заасан заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 12 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлыг үздэг.

Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан адитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлыг санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан болно.

Бусад асуудал

Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	208,891.7	131,147.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,076,953.8	5,194,968.7
	Нийт хөрөнгийн дүн	4,285,845.4	5,326,116.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,237,909.4	5,278,180.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,285,845.4	5,326,116.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,134,321.2	2,539,417.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,166,748.2	1,499,147.1
	Үйл ажиллагааны үр дүн	967,573.0	1,040,270.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	967,573.0	1,040,270.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,285,845.4	5,326,116.1
	Тайлант оны үр дүн	1,040,270.7	1,040,270.7
	Эцсийн үлдэгдэл	5,326,116.1	5,326,116.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,083,436.5	1,241,394.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,081,936.9	1,241,402.9
	Үйл ажиллагааны ЦМГ	1,499.6	(8.8)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,500.0)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.4)	(8.8)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8.8	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,029,828.2
	Урсгал зардал	-	1,029,828.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,029,828.2
	Орон нутгийн төсвөөс	-	1,029,828.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь 2025 онд Төрийн бодлого хууль тогтоомжийг сумын хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж иргэдэд чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоын хүрээнд дараах зоилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
- Нутгийн удирдлагын зохион байгуулалт
- Төрийн үйлчилгээ үзүүлэх
- Орон нутгийн хөгжлийг дэмжих
- Иргэд байгууллагатай хамтран ажиллах

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 15.2 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 26.5 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 11.05 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 46.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29.0 сая төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Нийт 4 албан хаагч нарт илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг 5.9 сая төгрөгийг холбогдох журамд нийцүүлэн олгоогүй нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Төрийн албан хаагчийн эзгүй орон тоог /нийгмийн бодлогын мэргэжилтэн, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ түр орлон гүйцэтгэсэний цалинг 5.9 сая төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Улиралын үр дүнгийн урамшууллыг олгохдоо /1 албан хаагч/ холбогдох тушаал, шийдвэр гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлж дүгнээгүйгээр 0.7 сая төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хасвралт 2.4, 2.5-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4. Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин ахмадын баярын арга хэмжээнд зориулан согтууруулах ундаа худалдан авахад 0.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн турхай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 -д заасан заалттай нийцээгүй,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин цагаан сарын мэндчилгээний зардалд 2.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах журмыг зөрчин 5.6 сая төгрөгийн хөрөнгө /гүйлтийн тэшүүр, тэшүүр ирлэгч суурь, ирлэгч хайрга/ худалдан авч зориулалт бус зарцуулсан, орлогод авч бүртгэлжүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин тэмцээн зохион байгуулж "Жудо" бөхийн тэмцээнд 2.0 , "Шагайн харваа" тэмцээнд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн турхай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 -д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Албан хаагчийн хувийн дансруу зохион байгуулах арга хэмжээний зардал 13.5 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, тухайн албан хаагчаар нэхэмжлэл үүсгэн ХХОАТ-ыг суутган тооцсон нь /ахмадын баяр, тэмцээн уралдаан, сумын аврага малчинд дурсгалын зүйл гардуулах/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолын 3.6.11, 3.6.8, 4.4.3.4-д заасан заалттай бүрэн нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангахгүй зөрчилд зөрчлийн таслан зогсоох дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

4. Сумын ЗДТГ-ын даргад гамшигаас хамгаалах асуудал хариуцсан албан тушаалтны ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж үндсэн цалингийн 40 хувиар тооцож нийт 4.1 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 23.6, 58.1.1-д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт дасны шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал , санхүүгийн тайлангийн аудитын ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс аймаг, сумын аваргаар тодорсон малчдад гарын бэлэг, дурсгалын зүйлд зориулан ний 6.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын аврага малчин тодруулах журмыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинчилж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт 4 албан хаагч нарт илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгохдоо холбогдох журмыг зөрчин олгосон.	1	5.9	1.0	5.9								
Сумын ЗДТГ-ын даргад гамшигаас хамгаалах асуудал хариуцсан албан тушаалтны ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж үндсэн цалингийн 40 хувиар тооцож нийт 4.1 сая төгрөгийг олгосон.	1	4.1			1.0	4.10						
Төрийн албан хаагчийн эзгүй орон тоог /нийгмийн бодлогын мэргэжилтэн, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ түр орлон гүйцэтгэсний цалинг илүү тооцон олгосон.	1	5.9	1.0	5.9								
Улиралын үр дүнгийн урамшууллыг олгохдоо /1 албан хаагч/ холбогдох тушаал, шийдвэр	1	0.7	1.0	0.7								

гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлж дүгнээгүйгээр олгосон													
Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах журмыг 5.6 сая төгрөгийн хөрөнгө /гүйлтийн тэшүүр, тэшүүр ирлэгч суурь, ирлэгч хайрга/ худалдан авч зориулалт бус зарцуулсан, орлогод авч бүртгэлжүүлээгүй	1	5.6			1.0	5.6							
Албан хаагчийн хувийн дансруу зохион байгуулах арга хэмжээний зардлыг шилжүүлэн зарцуулсан, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, тухайн албан хаагчаар нэхэмжлэл үүсгэн ХХОАТ-ыг суутган тооцсон	1	13.5			1.0	13.5							
Нэмэлт дасны шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн./мал тооллогын шатахууны үнэ/	1	4.5					1	4.5					
Засаг даргын нөөц хөрөнгөөс аймаг, сумын аваргаар тодорсон малчдад гарын бэлэг, дурсгалын зүйлд зориулан нийт 6.4 сая төгрөгийг зарцуулсан	1.0	6.4					1	6.4					
Дүн	8	46.69	3.0	12.59	3.0	23.2	2	4.50	6.4	0	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Дүн	0	0	0	0	0	0.0	0	0	0	0			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /терийн хэмнэлтийн тухай хууль/													

Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин ахмадын баярын арга хэмжээнд зориулан согтууруулах ундаа худалдан авахад 0.6 сая төгрөгийг зарцуулсан	1	0.6	1	0.6				
Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин тэмцээн зохион байгуулж "Жудо" бөхийн тэмцээнд 2.0 , "Шагайн харваа" тэмцээнд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан	1	3.2			1	3.2		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин цагаан сарын мэндчилгээний зардалд 2.0 сая төгрөгийг зарцуулсан	1	2.0	1	2.0				
Дүн	3	5.8	2	2.6	1	3.2	-	-
Нийт дүн	3	5.8	2	2.6	1.0	3.20	0	0